

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдөр
Тендер шалгаруулалтын нэр: **Драг 250ДС тоног төхөөрөмж, сэлбэг нийлүүлэх**
Тендер шалгаруулалтын дугаар: МРЦМ/202112021

“Монголросцветмет” ТӨҮГ эрх бүхий тендерт оролцогчдоос **Драг 250ДС тоног төхөөрөмж, сэлбэг** нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **50,000.00 /тавин мянган/** төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **2018, 2019, 2020 оны аль нэг жилийн гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ тендерийн үнийн саналын мөнгөн дүнгийн 50%-иас багагүй байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Тендерт ирүүлсэн үнийн саналын мөнгөн дүнгийн хэмжээ 50 хувиас багагүй байх байна.**

Тендерийн хамт нийт **2 634 630** /хоёр сая зургаан зуун гучин дөрвөн мянга зургаан зуун гуч/ төгрөгийн дүн бүхий тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 09:00 цагаас өмнө www.tender.gov.mn хаягаар ирүүлэх ба мөн өдрийн 09:05 цагт цахим системээр нээнэ.**

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **Зөвшөөрнө.**

Дотоодын давуу эрх тооцох эсэх. **Тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, БЗД 22-р хороо, Энхтайваны өргөн чөлөө – 98, 504 тоот өрөө, утас:
450060 + 152

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ